

**Үндэсний статистикийн хорооны
даргын 2008 оны 12 дугаар сарын 23-ны
өдрийн 01/171 тоот тушаалын хавсралт**

**ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ ДАНСУУД
БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ**

**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
2008 он**

Гарчиг

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Данс байгуулахад ашиглагдах ангилал

Гурав. Үндэсний тооцооны дансны хураангуй загвар, дансны үзүүлэлтүүд

3.1 Үйлдвэрлэлийн данс

3.1.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.1.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.1.3 *Баланслуулах үзүүлэлт*

3.2 Орлогын дансууд

3.2.1 Орлого бүрдэлтийн данс

3.2.1.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.2.1.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.2.1.3 *Баланслуулах үзүүлэлт*

3.2.2 Анхны орлого хуваарилалтын данс

3.2.2.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.2.2.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.2.2.3 *Баланслуулах үзүүлэлт*

3.2.3 Орлогын дахин хуваарилалтын данс

3.2.3.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.2.3.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.2.3.3 *Баланслуулах үзүүлэлт*

3.2.4 Орлого ашиглалтын данс

3.2.4.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.2.4.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.2.4.3 *Баланслуулах үзүүлэлт*

3.3 Хөрөнгийн данс

3.3.1 *Нөөцийн үзүүлэлт*

3.3.2 *Ашиглалтын үзүүлэлт*

3.3.3 *Баланслуулах үзүүлэлт*

Дөрөв. Хавсралт жишээ

Товчилсон үгийн тайлбар

ҮТС - Үндэсний тооцооны систем

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

ДЦБ - Дотоодын цэвэр бүтээгдэхүүн

НҮ - Нийт үйлдвэрлэлт

ЗХ - Завсрын хэрэглээ

БЦТ - Бүтээгдэхүүний цэвэр татвар

ҮХЭ - Үндсэн хөрөнгийн элэгдэл

ӨАА ҮАББ - Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллага

ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Нэг. Нийтлэг үндэслэл

- Үндэсний тооцооны систем нь өөр хоорондоо логик дэс дараалалтайгаар байгуулагдах макро эдийн засгийн цогц дансууд, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, ойлголт, тодорхойлолт, ангилал болон тооцооны арга зүйд үндэслэн зохиогддог тэнцэл, хүснэгтүүд (нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл)-ээс бүрдэнэ. ҮТС нь улс орны эдийн засгийн талаарх бүхий л мэдээлэл, эдийн засгийн бодит байдал, тулгамдсан асуудлыг харуулсан тооцооны иж бүрэн цогц систем бөгөөд энэ системийн хүрээнд тоон мэдээллүүд нь эдийн засгийн шинжилгээ хийх, шийдвэр гаргах, бодлого боловсруулахад тохиромжтой загварын дагуу нэгтгэгдсэн байдаг.
- ҮТС-ийн гол цөм нь үндэсний тооцооны дансууд бөгөөд тухайн улс орны эдийн засгийн үйл ажиллагааны талаарх бүхий л нарийвчилсан мэдээллийг харуулж, эдийн засгийн ерөнхий механизм, түүний ажиллах зарчмын дагуу зохион байгуулагдаж, ангилагдсан байдаг. Үндэсний тооцооны дансууд нь эдийн засгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгөөд зогсохгүй тухайн орны эдийн засаг дахь үйлдвэрлэлийн хэмжээ, хүн амын бэл бэнчин, хөрөнгийн хэмжээг тодорхой хугацааны байдлаар харуулж чаддагаараа ихээхэн ач холбогдолтой.
- Үндэсний тооцооны дансууд нь нэг талаас улс орны эдийн засгийн амьдралыг бүхэлд нь дүрслэн харуулахад чиглэгдсэн харилцан уялдаа бүхий үзүүлэлтүүдийн систем, нөгөө талаас эдийн засаг дахь секторууд хоорондын болон гадаад эдийн засагтай харилцаж байгаа харилцааг харуулахад чиглэгддэг.
- Улс орны эдийн засаг нь хөгжлийн түвшнээс үл хамааран **үйлдвэрлэл-хэрэглээ - хуримтлал** гэсэн гурван үндсэн шатаас бүрдэх бөгөөд эдгээрийн аль нэг нь нөгөөгүйгээр байх боломжгүй эдийн засгийн зүй тогтолтой.
- Үйлдвэрлэл нь юуны өмнө хэрэгцээг хангахад чиглэгддэг. Хэрэгцээг хангахын тулд үйлдвэрлэлийн шатанд бий болсон орлогыг хуваарилж зарцуулна. Дараагийн шатны үйлдвэрлэлд хуримтлал зайлшгүй шаардлагатай. Үйлдвэрлэл, хэрэглээ хоёрыг эдийн засгийн хоёр туйл гэж үзвэл хуримтлал, хуваарилалт нь тэдгээрийн завсрын шат болно. Эдийн засгийн энэ ерөнхий зүй тогтлыг тоогоор илэрхийлэх, харилцан нөлөөллийг нь илрүүлж харуулахад үндэсний тооцооны дансууд чухал үүрэгтэй.
- Үндэсний тооцооны дансанд тусгасан үзүүлэлт бүр эдийн засгийн тодорхой үйл ажиллагааг харуулах бөгөөд энэ нь аж ахуйн нэгж, байгууллагын авсан, нөгөө аж ахуйн нэгжийн өгсөн үйлдлийг агуулж байдаг. Энэ байдлыг тусгах үүднээс данс нь нөөц ба ашиглалт гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нөөц талд авсныг, ашиглалт талд өгснийг харуулна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн үйл ажиллагааны өгөх, авах үйлдлийг нэгэн зэрэг агуулж байгаа гэсэн үг. Нөөц ба ашиглалт хоёрын зөрүүг баланслуулах үзүүлэлт гэж нэрлэнэ. Урсгал дансны баланслуулах үзүүлэлтүүд нь **нийт, цэвэр** гэсэн 2 төрлөөр бичигдэнэ. Нийт гэсэн ухагдахуун нь үндсэн хөрөнгийн элэгдлийг шингээсэн, харин цэвэр гэдэг нь үндсэн хөрөнгийн элэгдлийг хасч цэвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
- Аж ахуйн нэгжийн эдийн засгийн үйлдэл бүр өгсөн, авсан хэлбэрээр дансуудад 2 газар зэрэг тусгагддаг. Үүнийг нягтлан бодох бүртгэлд давхар бичилтийн

зарчим гэх бөгөөд ҮТС-ийн дансуудын баланслуулах үзүүлэлтүүдийг мөн адил давхар бичилтийн зарчмаар буюу нэг дансны ашиглалт талаас нөгөө дансны нөөц талд тэр дүнгээр шилжүүлэн бичиж харуулдаг. Үүнтэй уялдаад дансуудыг хатуу тогтсон дэс дараалалтайгаар байгуулна.

Хоёр. Данс байгуулахад ашиглагдах ангилал

- Эдийн засгийн үйл ажиллагаанд *эдийн засгийн салбарын болон секторын* гэсэн хоёр үндсэн ангиллыг хэрэглэдэг. Салбарын ангиллыг ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцоход голчлон хэрэглэдэг бол секторын ангиллыг Үндэсний тооцооны дансуудыг байгуулахад хэрэглэнэ. Үндэсний тооцооны дансуудыг сектороор байгуулснаар тухайн үйл ажиллагаанд эдийн засгийн сектор тус бүрийн эзлэх байр суурь, харилцан уялдаа холбоог харуулна.
- ҮТС-д дотоодын эдийн засгийг олон улсын түвшинд түгээмэл мөрдөж байгаа 5 үндсэн секторт ангилах бөгөөд тэдгээр секторт улс орны эдийн засгийн бүхий л нэгжийн үйл ажиллагаа бүрэн багтсан байдаг. Эдийн засгийн секторын ангилалд гадаад эдийн засгийн секторыг бие даасан бүлэг болгон авч үздэг.
- Үндэсний статистикийн хорооны даргын 2008 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 01/57 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн секторын ангилал” нь эдийн засаг дахь санхүүгийн урсгал, орлого, зарлагыг эдийн засгийн сектороор харуулах зорилготой бөгөөд эдийн засгийн нэгжүүд ямар үйл ажиллагаа эрхэлж байгаа нь гол биш харин орлого, эцсийн хэрэглээ, санхүүгийн үйл ажиллагаатай ямар холбоотой байгааг гол шалгуур болгож авч үздэг.

Санхүүгийн бус сектор: Зах зээлд борлуулахаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, санхүүгийн бус үйлчилгээ үзүүлж, орлогоороо зардлаа нөхдөг бие даасан аж ахуйн нэгжийг санхүүгийн бус секторт хамруулна. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт буюу санхүүгийн бус салбарт зах зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн бус байгууллагуудыг энэ секторт хамруулна.

Санхүүгийн сектор: Санхүүгийн зуучлагчид, түүнтэй холбоотой туслах үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийг санхүүгийн секторт багтааж ойлгоно. Санхүүгийн салбарт зах зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашгийн бус байгууллагуудыг мөн энэ секторт хамруулна. Санхүүгийн зуучлал нь бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас онцлог ялгаатай бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг учраас ҮТС-ийн секторын ангилалд бие даасан үйл ажиллагаа гэж тусгайлан авч үзнэ.

Төрийн байгууллагын сектор: Төр, засгийн байгууллага үйл ажиллагаандаа зориулж орлого бүрдүүлэн, мөн түүнийгээ тодорхой чиглэлээр зарцуулж байгаагийн хувьд эдийн засгийн энэхүү секторт хамаарах нэгж болно.

Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд болох төрийн байгууллагуудыг энэ секторт хамруулна.

Өрхийн аж ахуйн сектор: Өөрийн эцсийн хэрэглээнд, эсвэл зах зээлд борлуулахаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийг өрхийн аж ахуйн секторт хамруулна. Өрх нь үйлдвэрлэгч байхаас гадна зах зээлд ажиллах хүч нийлүүлэгч, мөн эцсийн хэрэглэгч байна. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэгчид нэгдэн хоршдоггүй бөгөөд бие даасан тайлан баланс гаргах боломжгүй байдаг.

Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын сектор: Өөрийн гишүүд болон өрхүүдэд бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, үйлчилгээг үзүүлэхдээ үнэ төлбөргүй юм уу эсвэл зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулдаг, үүсгэн байгуулагч болон тэдгээрийг санхүүжүүлэгч, удирдах нэгждээ ашиг олох хэрэгсэл нь болдоггүй ашгийн бус байгууллагууд энэ секторт хамрагдана.

Гурав. Үндэсний тооцооны дансны хураангуй загвар, дансны үзүүлэлтүүд

- Дотоодын эдийн засагт үндэсний тооцооны дараах 4 томсгосон дансыг байгуулдаг. Үүнд:
 1. Үйлдвэрлэлийн данс
 2. Орлогын данс
 3. Хөрөнгийн данс
 4. Санхүүгийн данс

- Дээрх дансуудыг дотор нь **урсгал данс, хуримтлалын данс** гэж хоёр ангилна. Үйлдвэрлэл, орлогын дансууд нь **урсгал дансыг**, хөрөнгийн болон санхүүгийн данс, түүнчлэн актив дахь бусад өөрчлөлтийн данс (туслах данс) нийлээд **хуримтлалын дансыг** бүрдүүлнэ. Урсгал дансууд нь эдийн засгийн үйлдлүүд актив, пассивын тэнцэлд шууд нөлөө үзүүлдэггүй бол хуримтлалын дансуудад тусгагдсан эдийн засгийн үйлдлүүдийн үр дүнд актив, пассивын хэмжээ, өртөг өөрчлөгдөхөд хүрдэг.

- Орлогын дансууд нь дараах 4 төрөлд хуваагдана. Үүнд:
 - Орлого бүрдэлтийн данс
 - Анхны орлого хуваарилалтын данс
 - Орлогын дахин хуваарилалтын данс
 - Орлого ашиглалтын данс

- Хуримтлалын данс нь эдийн засагт явагдсан үйлдлүүд болон үндэсний баялагт ямар өөрчлөлт орсныг харуулна. **Хөрөнгийн данс** нь санхүүгийн бус хөрөнгө, түүний шилжүүлэгтэй холбогдсон үйлдлүүдийг тусгадаг бол **санхүүгийн данс** нь санхүүгийн хөрөнгөтэй холбоотой үйлдлүүдийг илэрхийлдэг. Өнөөгийн байдлаар санхүүгийн дансыг байгуулах мэдээллийн эх үүсвэр хангалтгүйгээс энэхүү аргачлалд хуримтлалын эхний данс болох хөрөнгийн данс байгуулах талаар тусгалаа.

- Үндэсний тооцооны дансны загварыг Бүдүүвч 1-д дараах байдлаар харуулав.

Бүдүүвч 1. Үндэсний тооцооны дансны хураангуй загвар

<u>Ашиглалт</u>	<u>Нөөц</u>
Үйлдвэрлэлийн данс	
Завсрын хэрэглээ	Нийт үйлдвэрлэлт (зах зээлийн үнээр) Бүтээгдэхүүний татвар, татаас
<i>Баланслуулах үзүүлэлт:</i>	Дотоодын бүтээгдэхүүн, <i>нийт/цэвэр</i> Гадаад урсгал гүйлгээний тэнцэл
Орлого бүрдэлтийн данс	
Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс Бүтээгдэхүүний татвар Бүтээгдэхүүний татаас	Дотоодын бүтээгдэхүүн, <i>нийт/цэвэр</i>

<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Ашиг/холимог орлого, <i>нийт/цэвэр</i>	
Анхны орлого хуваарилалтын данс	
Өмчийн орлого, өгсөн	Ашиг/холимог орлого, <i>нийт/цэвэр</i> Өмчийн орлого, авсан Цалин, түүнтэй адилтгах орлого Үйлдвэрлэлийн болон импортын татвар, татаас
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Анхны орлогын үлдэгдэл, <i>нийт/цэвэр</i> , Үндэсний орлого, <i>нийт/цэвэр</i>	
Орлогын дахин хуваарилалтын данс	
Урсгал шилжүүлгүүд, өгсөн	Анхны орлогын үлдэгдэл, <i>нийт/цэвэр</i> Урсгал шилжүүлгүүд, авсан
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Эзэмшлийн орлого, <i>нийт/цэвэр</i>	
Орлого ашиглалтын данс	
Эцсийн хэрэглээний зарлага	Эзэмшлийн орлого, <i>нийт/цэвэр</i>
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Хадгаламж, <i>нийт/ цэвэр</i>	
Хөрөнгийн данс	
Нийт үндсэн хөрөнгийн хуримтлал Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт Үнэт зүйлсийн хуримтлал Үндсэн хөрөнгийн элэгдэл Үйлдвэрлэгдээгүй санхүүгийн бус активын өсөлт (хорогдлыг хассан)	Хадгаламж, <i>нийт/ цэвэр</i> Хөрөнгийн шилжүүлгүүд, авсан Хөрөнгийн шилжүүлгүүд, өгсөн
<i>Баланслуулах үзүүлэлт:</i> Цэвэр зээлжүүлэлт (+)/Цэвэр өглөг Хадгаламж, хөрөнгийн шилжүүлэгд гарсан өөрчлөлт	

3.1 Үйлдвэрлэлийн данс

- Дансуудын анхдагч нь үйлдвэрлэлийн данс юм. Энэ данс нь үйлдвэрлэлийн эцсийн үр дүн болох ДНБ-ийг нийт эдийн засгийн түвшинд; нэмэгдэл өртгийг секторын түвшинд баланслуулах үзүүлэлт болгож харуулах зорилготой.
- Үйлдвэрлэлийн дансны нөөц талд үндсэн үнээр үнэлэгдсэн бараа, үйлчилгээний нийт хэмжээ буюу нийт үйлдвэрлэлтийг сектороор; бүтээгдэхүүний цэвэр татварыг нийт эдийн засгийн түвшинд буюу зөвхөн улсын дүнгээр нь тусгадаг бол ашиглалт талд худалдан авагчийн үнээр тооцсон завсрын хэрэглээг тусгадаг бөгөөд энэ дансны баланслуулах үзүүлэлт болох ДНБ-ийг үйлдвэрлэгчийн үнээр тооцно.

3.1.1 Нөөцийн үзүүлэлт

Дансны нөөц талын анхдагч үзүүлэлт нь нийт үйлдвэрлэлтийн хэмжээ байна.

Нийт үйлдвэрлэлт: Үйлдвэрлэлийн дансанд тусгагдсан нийт үйлдвэрлэлт нь хэрхэн ашиглагдаж байгаагаасаа шалтгаалан - *зах зээлийн нийт үйлдвэрлэлт*, - *өөрийн хэрэглээнд зориулсан нийт үйлдвэрлэлт*, - *зах зээлийн бус бусад нийт үйлдвэрлэлт* гэж хуваагддаг. Нийт үйлдвэрлэлт нь тухайн секторын эдийн засгийн үйл ажиллагааны онцлогоос хамааран секторуудын хувьд харилцан адилгүйгээр хуваагддаг. Тухайлбал, санхүүгийн болон санхүүгийн бус секторын нийт үйлдвэрлэлт нь зах зээлд худалдан борлуулагдах зориулалттай байдаг тул бүхэлдээ зах зээлийн нийт үйлдвэрлэлт болдог. Харин төрийн удирдлага, ӨАА-д үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторын нийт үйлдвэрлэлт нь зах зээлд худалдан борлуулах зориулалтгүй, нийгмийн сайн сайхны төлөө зарцуулагддаг.

Иймд зах зээлийн бус нийт үйлдвэрлэлт болно. Өрхийн аж ахуйн секторын нийт үйлдвэрлэлт нь үндсэндээ тухайн өрхийн эцсийн хэрэглээнд эргэж очдог учраас өөрийн хэрэглээнд зориулсан нийт үйлдвэрлэлт гэж ангилагдана.

Зах зээлийн үйлдвэрлэлт явуулдаг нэгжийн нийт үйлдвэрлэлтийг үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, бусад орлогын нийлбэрээр тооцон, **зах зээлийн нийт үйлдвэрлэлт** гэж тусгана.

Өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өөрийн эцсийн хэрэглээнд хэрэглэсэн бол түүнийг нийт үйлдвэрлэлтийн хэмжээнд тусган, **өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан нийт үйлдвэрлэлт** гэж үзнэ.

Зах зээлийн бус үйлдвэрлэлт явуулдаг нэгжийн нийт үйлдвэрлэлтийг тухайн жилд зарцуулсан нийт урсгал зардлын хэмжээгээр тооцон, **зах зээлийн бус нийт үйлдвэрлэлт** гэж үзнэ.

Нийт үйлдвэрлэлтийг зах зээлийн ба зах зээлийн бус гэж 2 ангилна. Манай орны хувьд өөрийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлтийг салгахад хүндрэлтэй байдаг.

Бүтээгдэхүүний цэвэр татвар: Бүтээгдэхүүний цэвэр татварыг тооцохдоо улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээний татвараас улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлд тусгагдсан татаасын хэмжээг хасч тодорхойлно.

Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлээс авах бараа, ажил, үйлчилгээний татвар:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Онцгой албан татвар
- Гадаад үйл ажиллагааны орлогын албан татвар

Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээс авах бараа, ажил, үйлчилгээний үнийн татаас:

- Эрчим хүч, дулааны алдагдлын татаас
- Нийтийн тээврийн үйлчилгээний татаас

Бүтээгдэхүүний цэвэр татварыг зөвхөн улсын дүн дээр бичнэ.

3.1.2 Ашиглалтын үзүүлэлт

Завсрын хэрэглээ: Үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулахын тулд зарцуулсан материалын зардал (хөрөнгө оруулалтын зардал орохгүй) болон үйлчилгээний төлбөрийг завсрын хэрэглээний зардал гэж үзнэ. Үүнд: үндсэн, туслах материал, түүхий эд, эрчим хүч, ус, шатахуун, шатах тослох материал, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, үйлдвэрлэл явуулахад хэрэглэсэн түлээ, нүүрс, барилга, байшин, тоног төхөөрөмж түрээсэлсэний зардал, гадны байгууллага, тээврээр үйлчлүүлсний төлбөр, албан томилот, баяр ёслолын үйл ажиллагааны зардал, шуудан, холбоо, эргэлтийн бус сав баглаа боодол, ном, хэвлэл захиалга, бичиг хэрэгслэл, дахин сургалт, даатгал, харуул хамгаалалт, хөдөлмөр хамгаалал, зар сурталчилгааны зардал, үндсэн бус үйл ажиллагааны бусад зардал (ногдол ашгийн зардал, валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн алдагдал орохгүй) зэрэг зардлыг хамруулна.

3.1.3 Баланслуулах үзүүлэлт

Нэмэгдэл өртөг/Дотоодын нийт бүтээгдэхүүн: Улс орны эдийн засгийн хөгжлийг харуулдаг чухал үзүүлэлт юм. Хүний аливаа зорилго чиглэлтэйгээр,

тодорхой хэмжээний хөдөлмөр, хөрөнгө зарцуулсан үйл ажиллагааны үр дүнг ДНБ-ээр хэмжинэ. ДНБ нь улс орны хил хязгаарын дотор тайлант хугацаанд эдийн засгийн болон нийгмийн үйлчилгээний хүрээнд шинээр бүтээгдсэн нэмэгдэл өртгийн нийлбэр юм. ДНБ-ийг нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээний зөрүүгээр тооцно.

Үндсэн хөрөнгийн элэгдэл: Тайлант хугацаанд ашиглагдсан үндсэн хөрөнгөөс байгуулсан элэгдлийн хэмжээг үндсэн хөрөнгийн элэгдэл гэнэ.

ДНБ-ээс үндсэн хөрөнгийн элэгдлийг хасч Дотоодын цэвэр бүтээгдэхүүнийг тооцож үйлдвэрлэлийн дансанд тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийн үзүүлэлтүүдийн мэдээллийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн аргаар, эдийн засгийн сектороор тооцсон ДНБ-ий тооцоо байна. Харин бүтээгдэхүүний татвар, татаасын хэмжээг секторын хувьд байгуулсан дансуудад тусгалгүйгээр улсын дүнгээр тооцож үйлдвэрлэлийн дансны нөөц талын “дүн” гэсэн баганад тусгана.

- **Үйлдвэрлэлийн данс, эдийн засгийн гадаад секторын бараа, үйлчилгээний дансны уялдаа:** Эдийн засгийн гадаад секторын бараа, үйлчилгээний данснаас дараах үзүүлэлтүүдийг авч, үйлдвэрлэлийн дансны гадаад сектор гэсэн баганад тусгана.

- Импорт
 - Барааны импорт
 - Үйлчилгээний импорт
- Экспорт
 - Барааны экспорт
 - Үйлчилгээний экспорт
- Манай улс гадаадаас авсан буюу импортыг нөөц талд, харин гадагшаа гаргасан буюу экспортыг ашиглалт талд тусгана. Монгол банкнаас зарладаг ам.долларын төгрөгтэй харьцах жилийн дундаж ханшийг ашиглан төгрөгт шилжүүлнэ.
- Эдийн засгийн гадаад секторын бараа, үйлчилгээний дансны баланслуулах үзүүлэлт нь гадаад урсгал баланс буюу цэвэр экспорт байна.

Мэдээллийн эх үүсвэр: Монгол банкны төлбөрийн тэнцлийн жилийн эцсийн гүйцэтгэлээс авна. Тэнцлийн дебит талд бичигдсэн импортын гүйцэтгэл нь нөөцийн талд, кредит талд бичигдсэн экспорт нь ашиглалтын талд тусгагдана.

- Үйлдвэрлэлийн дансны баланслуулах үзүүлэлтийг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$\text{ДНБ} = (\text{НҮ} - \text{ЗХ}) + \text{БЦТ}$$

$$\text{ДЦБ} = \text{ДНБ} - \text{ҮХЭ}$$

$$\begin{aligned} \text{Гадаад урсгал гүйлгээний тэнцэл} &= \text{Бараа, үйлчилгээний импорт} \\ &\quad - \text{Бараа, үйлчилгээний экспорт} \end{aligned}$$

3.2 Орлогын дансууд

3.2.1 Орлого бүрдэлтийн данс

- Орлого бүрдэлтийн данс нь эдийн засгийн секторуудад орлого хэрхэн бүрэлдэж бий болдгийг харуулдаг. Дансны нөөц талд нэмэгдэл өртгийн дүнг үйлдвэрлэлийн данснаас шууд авч нөхөх бол ашиглалт талд цалин хөлс, татвар, татаасыг тусгана.
- Баланслуулах үзүүлэлт нь үйл ажиллагааны ашиг болон холимог орлого байна.
- Өрхийн аж ахуй, хоршоогүй эдийн засгийн жижиг нэгжүүдийн хувьд тэнд ажиллаж буй өрхийн гишүүдэд тодорхой тогтоосон хэмжээний цалин, хөлс олгодоггүй бөгөөд энэ орлого, цалинг ялгах боломжгүй учир түүнийг холимог орлого гэж нэрлэдэг. Холимог орлого нь өрхийн аж ахуйн секторт голлон тооцогддог үзүүлэлт юм.
- Орлого бүрдэлтийн дансны баланслуулах үзүүлэлтийг тооцохдоо эдийн засгийн секторууд болон нийт эдийн засгийн хувьд арай өөр байдлаар тооцдог. Секторуудын хувьд тооцохдоо дансны нөөц талд тусгагдсан секторын нэмэгдэл өртгөөс ашиглалт талд тусгагдсан тухайн секторын ажиллагчдын цалин, хөлсийг хасч тооцно.
- Нийт эдийн засгийн хувьд дансны нөөц талд тусгагдсан ДНБ-ээс ашиглалт талд тусгагдсан ажиллагчдын цалин, хөлс, импорт болон үйлдвэрлэлийн татварын нийт хэмжээг хасч, татаасын нийт хэмжээг нэмэх замаар баланслуулах үзүүлэлтийг тооцно.

3.2.1.1 Нөөцийн үзүүлэлт

Нэмэгдэл өртөг/Дотоодын нийт бүтээгдэхүүн: Дансны нөөц талд нэмэгдэл өртгийг үйлдвэрлэлийн данснаас шууд авч нөхнө.

3.2.1.2 Ашиглалтын үзүүлэлт

Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс: Энэхүү үзүүлэлтийг дотор нь цалин хөлс, НДШ, ЭМДШ-ийн төлбөр гэж ангилна.

- *Цалин хөлс* гэдэг нь тухайн тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас өөрийн ажиллагчдадаа зарцуулсан хөдөлмөрийн хувь хэмжээнд нь тохируулан мөнгөн болон биет хэлбэрээр олгосон нөхөн төлбөрийг хэлнэ.
- *Нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр* нь ажил олгогчийн төлж буй шимтгэлийн хэмжээгээр тодорхойлогдоно.

Бүтээгдэхүүний татвар: Энд үйлдвэрлэлийн дансанд нийт дүнгээр тусгагдсан бүтээгдэхүүний татварыг төрлөөр нь салгаж тусгах ба түүн дээр үйлдвэрлэлийн бусад татварыг нэмж тусгана. Үйлдвэрлэлийн бусад татварт газар, байгалийн нөөц ашигласны зэрэг татварууд орно. Манай орны хувьд эдгээр татвар нь үндсэн үнээрх нийт үйлдвэрлэлтэд буюу ашиг/холимог орлогод орсон байдаг тул үйлдвэрлэлийн бусад татварыг тусад нь тооцдоггүй. Иймд үйлдвэрлэлийн дансанд тусгагдсан бүтээгдэхүүний татварыг төрлөөр нь салгаж зөвхөн улсын дүнгээр тусгана.

Бүтээгдэхүүний татаас: Энд бүтээгдэхүүний татаас, үйлдвэрлэлийн бусад татаасыг тусгана. Үйлдвэрлэлийн бусад татаас гэдэгт аж ахуйн нэгж байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсвэл удаан хугацаагаар ажилгүй байсан иргэдийг ажиллуулж байгаад нь зориулж цалингийн санд төсвөөс олгосон нэмэгдэл зардал,

тухайн байгууллагаас зохион байгуулсан сургалтын зардлыг бүрэн эсвэл хэсэгчлэн даасан төсвийн зардал, байгаль орчны бохирдлыг багасгахтай холбогдон гарсан зардлыг бүрэн эсвэл хэсэгчлэн даасан төсвийн зардлуудыг ойлгоно. Манай орны хувьд үйлдвэрлэлийн бусад татаас гэж одоогоор гардаггүй. Иймд үйлдвэрлэлийн дансанд тусгагдсан бүтээгдэхүүний татаасыг төрлөөр нь салгаж, зөвхөн улсын дүнгээр тусгана.

3.2.1.3 Баланслуулах үзүүлэлт

Ашиг/холимог орлого: Ашиг/холимог орлого нь зах зээлийн үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны эцсийн үр дүнг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд үндсэндээ ашиг, борлуулалтын үнэ дээр нэмэгдсэн төрөл бүрийн үнийн зөрүүгээс олсон орлого юм. Ашиг нь аж ахуй эрхлэгчдийн гол цэвэр орлого бөгөөд татвар төлөхийн өмнөх анхдагч ашиг юм. Энэ үзүүлэлт нь өрхийн аж ахуйгаас бусад секторт тооцогдоно. Харин өрхийн аж ахуй эрхлэгчдийн зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын ашгийн зарим хэсэг нь тэдний өрхийн хэрэглээг хангах, цалинтай адилтгах орлогын эх үүсвэр болдгийн зэрэгцээ тодорхой зарим хэсэг нь аж ахуйн нэгжийн ашгийн адил цаашид үйлдвэрлэл явуулахад зориулагддаг. Энэ онцлогоос шалтгаалж өрхийн аж ахуйн ашгийг холимог орлого гэдэг.

Ашиг/холимог орлогыг үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэмэгдэл өртгөөс цалин, түүнтэй адилтгах орлого, үндсэн хөрөнгийн хэрэглээ, бараа, үйлчилгээний татварыг хасч, татаасыг нэмэх замаар тооцно.

Мэдээллийн эх үүсвэр: Орлого бүрдэлтийн дансны нөөц талд нэмэгдэл өртөг (ДНБ)-ийг үйлдвэрлэлийн данснаас шууд авч, ашиглалт талд цалин хөлс, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг үйлдвэрлэлийн аргаар, эдийн засгийн сектороор тооцсон ДНБ-ий тооцооноос авч харгалзах багануудад тусгана. Нийт болон цэвэр ашиг/холимог орлогыг дараах байдлаар тодорхойлно.

Ашиг/холимог орлого, *нийт/цэвэр* = Дотоодын бүтээгдэхүүн, *нийт/цэвэр*
- Цалин, түүнтэй адилтгах орлого
- Бүтээгдэхүүний татвар
- Бүтээгдэхүүний татаас

3.2.2 Анхны орлого хуваарилалтын данс

- Энэхүү данс нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олсон анхдагч орлогын хуваарилалтыг харуулах зориулалттай болно. Дансны нөөцөд хоёр төрлийн орлогыг тусгадаг. Эхнийх нь орлого бүрдэлтийн данснаас шууд шилжүүлэн бичдэг ашиг, цалин хөлс, татвар, татаас юм. Цалинг орлого бүрдэлтийн дансанд үйлдвэр, аж ахуйн газар, төрийн удирдлагын болон арилжааны бус байгууллагуудаас өрхийн аж ахуйд төлж байгаа хэлбэрээр тусгадаг бол энэ дансанд өрхийн аж ахуйн авсан орлогын хэлбэрээр харуулна. Өөрөөр хэлбэл орлого бүрдэлтийн дансанд нэмэгдэл өртгийн ашиглалтыг харуулдаг бол энэхүү дансанд анхны орлогын нөөц буюу орлогын байршлыг тусгадгаараа онцлогтой.

3.2.2.1 Нөөцийн үзүүлэлт

Ашиг/холимог орлого: Орлого бүрдэлтийн дансны баланслуулах үзүүлэлт болох ашиг/холимог орлогыг шууд авч тусгана.

Бүтээгдэхүүний татвар: Орлого бүрдэлтийн дансны улсын дүн гэсэн баганад тусгагдсан бүтээгдэхүүний татварыг шууд авч *төрийн байгууллагын сектор*т тусгана. Татварыг төрийн байгууллага төвлөрүүлэн хураан авч, зарцуулдагтай холбогдон дээрх байдлаар тусгадаг.

Бүтээгдэхүүний татаас: Орлого бүрдэлтийн дансны улсын дүн гэсэн баганад тусгагдсан татаасыг шууд авч *төрийн байгууллагын сектор*т тусгана.

Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс: Энэхүү үзүүлэлтийг орлого бүрдэлтийн данснаас шууд авч *өрхийн аж ахуйн сектор*т тусгана. Хөдөлмөрийн хөлс нь өрхийн аж ахуйн орлого буюу нөөцийн эх үүсвэр юм.

Өмчийн орлого: Анхны орлогын дараагийн нэг төрөл нь өмчийн орлого юм. Өмчийн орлого нь материаллаг баялаг үйлдвэрлэхэд оролцдоггүй, хөрөнгө болон санхүүгийн активыг бусдад ашиглуулсны төлөө энэхүү хөрөнгийг эзэмшиж байгаа эзэмшигчийн авч байгаа орлого юм. Өмчийн орлогод дараахь зүйлсийг хамруулан ойлгодог. Үүнд:

Хүү: Хүү гэдэг бол хадгаламж, үнэт цаас (акцаас бусад), зээлийн хөрөнгө зэрэг санхүүгийн тодорхой төрлийн активыг эзэмшигчдийн авч байгаа орлого юм. Тухайлбал: санхүүгийн зуучлагч байгууллагууд болон бусад аж ахуйн нэгжүүд гэхэд эдийн засгийн бусад сектор, хүн амын сул чөлөөтэй мөнгийг хуримтлуулан авч түүнийгээ цааш нь хөрөнгө мөнгө дутагдалтай байгаа нэгжүүд, хувь хүнд тодорхой нөхцөлтэйгээр зээлдүүлнэ. Ингэхдээ бусад нэгжийн мөнгөн хөрөнгийг авч ашигласны төлөө хүү төлж, бусдад зээлдүүлсний төлөө хүү авна. Үнэт цаасны хүүд вексель, облигаци зэргийн хүү орно. Авч байгаа хүүгийн хэмжээг нөөцөд тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Санхүүгийн бус секторын хүүгийн орлогыг салбаруудын бүтээгдэхүүний тооцооноос авч нөхнө.

Санхүүгийн секторын хүүгийн орлогыг уг секторын бүтээгдэхүүний тооцооноос авч нөхнө. Нөхөхдөө хүүгийн зардлыг авна. Учир нь санхүүгийн байгууллагууд нь зуучлалын үүрэг гүйцэтгэдэг тул тэдгээрийн гаргасан хүүгийн зардал нь үндсэндээ хүүгийн орлогоор төлөгддөг гэж үзнэ.

Төрийн байгууллагын секторын хувьд улсын төсвийн мэдээнд тусгасан хүүгийн орлого, ашиглалт талд гадаад эдийн засгийн секторт тусгасан хүүгийн хэмжээг тусгана.

Өрхийн аж ахуйн секторын хүүгийн орлогыг тусгахдаа “Арилжааны банкны орлого, зарлагын мэдээлэл ББ-1” маягтын хадгаламжийн хүүгийн зардлын дүнг ашиглана.

Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторын хүүгийн орлогыг төрийн бус байгууллагын бүтээгдэхүүний тооцооноос авч тусгана.

Ногдол ашиг: Ногдол ашиг (дивиденд) гэдэг нь хувь нийлүүлсэн үйлдвэр, аж ахуйн газарт оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр, тэдгээрийн үйл ажиллагааны эцсийн үр дүнгээс хувьцаа эзэмшигчдийн авч байгаа орлого юм.

Мэдээллийн эх үүсвэр: Санхүүгийн секторын авсан ногдол ашгийн орлогыг уг секторын бүтээгдэхүүний тооцооноос авч нөхнө. Мөн гадаад эдийн засгийн секторын ашиглалт талд тусгасан ногдол ашгийн хэмжээг тусгана.

Санхүүгийн бус секторын авсан ногдол ашгийн орлогыг уг секторын бүтээгдэхүүний тооцооноос авч нөхнө.

Төрийн байгууллагын секторын ногдол ашгийн орлогыг улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлээс хувьцааны ногдол ашгийн дүнг авна.

Өрхийн аж ахуйн секторын ногдол ашгийн орлогыг тооцохдоо Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны бусад орлого гэсэн бүлгийн хувьцааны ногдол болон бондын ашгийн орлогын мэдээллийг ашиглана.

Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын секторын ногдол ашгийн орлогыг төрийн бус байгууллагын бүтээгдэхүүний тооцооноос авч тусгана.

Түрээс: Түрээс гэдэг нь газар болон газрын доорхи баялаг буюу ашигт малтмалыг бусдад эзэмшүүлэн, түүнийг түрээслэгчдээс авч байгаа өмчийн орлогын нэг төрөл юм. Манайд дараахь төрлийн төлбөр хураамжууд байдаг.

Үүнд:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Газрын төлбөр
- Ашигт малтмалаас бусад баялаг ашигласны төлбөр
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр

Түрээсийг тооцож авсан тэр хэмжээгээр нь дансанд тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Улсын нэгдсэн төсвийн орлогын мэдээнээс авч Төрийн байгууллагын секторт тусгана.

3.2.2.2 Ашиглалтын үзүүлэлт

- Анхны орлого хуваарилалтын дансны ашиглалтын талд хуваарилсан өмчийн орлогыг тусгана.

Өмчийн орлого:

Хүү: Хадгаламж, үнэт цаас (акцаас бусад), зээлийн хөрөнгө зэрэг санхүүгийн тодорхой төрлийн активыг эзэмшигчдэд төлсөн хүүгийн хэмжээг ашиглалт талд тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Санхүүгийн бус секторын хувьд уг секторын бүтээгдэхүүний тооцооноос зээлийн хүүгийн зардлыг авна.

Санхүүгийн секторын бүтээгдэхүүний тооцооноос хадгаламжийн хүүгийн зардлыг авна.

Төрийн байгууллагын секторын хувьд улсын нэгдсэн төсвийн зарлагын мэдээний дотоодын зээлийн хүүгийн зардал, нөөц талд гадаад эдийн засгийн секторт тусгагдсан хүүгийн хэмжээг авч тусгана.

Өрхийн аж ахуйн секторын хувьд “Иргэд, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжид олгосон зээлийн улирлын тайлан ЗТ-1а” маягын зээлийн хүүг тусгана.

Ногдол ашиг: Хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийг тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Нөөц талд тусгагдсан ногдол ашгийг Санхүүгийн секторт тусгана. Мөн гадаад эдийн засгийн секторын нөөц талд тусгасан ногдол ашгийн хэмжээг Санхүүгийн секторт тусгаж харуулна.

Түрээс: Секторуудын төлсөн түрээсийг тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Нөөцийн талд тусгагдсан түрээсийн орлогын хэмжээг секторуудад хуваарилна. Үүнд 8 үйлдвэрлэлийн аргаар, эдийн засгийн сектороор тооцсон ДНБ-ий тооцоонд тусгагдсан газар, байгалийн нөөц ашигласны төлбөрийн дүнд секторуудын эзлэх хувийн жинг ашиглана.

3.2.2.3 Баланслуулах үзүүлэлт

- Дансны баланслуулах үзүүлэлт нь **секторуудын хувьд анхны орлогын үлдэгдэл**, нийт эдийн засгийн хувьд **үндэсний орлого** байна.
- **Анхны орлого хуваарилалтын данс, эдийн засгийн гадаад секторын анхны орлого, урсгал шилжүүлгийн дансны үялдаа:** Анхны орлого хуваарилалтын данс нь эдийн засгийн гадаад секторын анхны орлого, урсгал шилжүүлгийн данстай салшгүй холбоотой. Уг данснаас дараах үзүүлэлтүүдийг авч, анхны орлого хуваарилалтын дансны гадаад сектор буюу бусад орон гэсэн баганад тусгана.
 - Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс
 - Хувийн гуйвуулга
 - Өмчийн орлого
 - Хүү (санхүүгийн хөрөнгө болон бусад хөрөнгө оруулалтын орлого)
 - Ногдол ашиг

Хувийн гуйвуулга нь гадаадад ажиллаж буй манай орны иргэдийн хөдөлмөрийн хөлснөөс шилжүүлж буй мөнгөнд үндэслэн тооцогддог тул энэ үзүүлэлт нь өрхийн орлогын томоохон эх үүсвэрийн нэг болдог. Иймд хувийн гуйвуулгыг анхны орлого хуваарилалтын дансанд цалин хөлс байдлаар тусгана.

Манай улсад гадаадаас орж ирвэл ашиглалт талд, харин гадаадад шилжүүлсэн байвал нөөц талд тусгана. Монгол банкнаас зарладаг ам.долларын төгрөгтэй харьцах жилийн дундаж ханшийг ашиглан төгрөгт шилжүүлнэ.

Мэдээллийн эх үүсвэр: Монгол банкны төлбөрийн тэнцлийн жилийн эцсийн гүйцэтгэлээс авна. Тэнцлийн дебит талд бичигдсэн гүйцэтгэл нь нөөцийн хэсэгт, кредит талд бичигдсэн нь ашиглалтын хэсэгт тус тус тусгагдана.

Төлбөрийн тэнцлээс авсан дээрх үзүүлэлтүүдийн, гаднаас орж ирсэн болон гадагш шилжүүлсэн хэмжээг дотоод эдийн засгийн секторт тусгана. Гадаадаас орж ирсэн хувийн гуйвуулгыг Өрхийн аж ахуйн секторын нөөц талын цалин хөлс гэсэн үзүүлэлт дээр нэмж, гадаадад шилжүүлснийг мөн үзүүлэлтээс хасч тусгана. Гадаадаас орж ирсэн хүүг Төрийн байгууллагын секторын нөөц талд, гадаадад шилжүүлсэн хүүг Төрийн байгууллагын секторын ашиглалт талд, гадаадаас орж ирсэн ногдол ашгийг Санхүүгийн бус секторын нөөц талд, гадаадад шилжүүлсэн ногдол ашгийг Санхүүгийн бус секторын ашиглалт талд тус тус нэмж тусгана. Төлбөрийн тэнцлийн мэдээллийг хэрхэн тусгахыг жишээгээр үзүүлбэл:

(сая төг)

АШИГЛАЛТ			НӨӨЦ			
Гадаад эдийн засгийн сектор	Төрийн байгууллагын сектор	Санхүүгийн бус сектор	Үйл ажиллагаа ба баланслуулах статья	Төрийн байгууллагын сектор	Өрхийн аж ахуйн сектор	Гадаад эдийн засгийн сектор
208453.6			Цалин хөлс		837476.4+208453.6- -105689.8	105689.8
58218.4	918.8+29158.0		Хүү	23691.5+58218.4		29158.0
		145557.0+126089.3	Ногдол ашиг			126089.3

- **Анхны орлогын үлдэгдэл/үндэсний орлогыг** дараах байдлаар тодорхойлно.

Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний орлого, *нийт/цэвэр* = Ашиг/холимог орлого, *нийт/цэвэр*
 + Ажиллагчдын хөдөлмөрийн хөлс
 + Бүтээгдэхүүний татвар
 + Бүтээгдэхүүний татаас
 + Өмчийн орлого, авсан
 - Өмчийн орлого, өгсөн

3.2.3 Орлогын дахин хуваарилалтын данс

- Орлогын дахин хуваарилалтын данс нь, секторуудын анхны орлогын үлдэгдэл нь урсгал шилжүүлгийн дүнд хэрхэн эзэмшлийн орлого болж хувирахыг харуулна. Шилжүүлэг гэдэг нь аж ахуйн нэг нэгж, нөгөө нэгждээ ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус актив юм. Үүнийг дотор нь урсгал, хөрөнгийн гэж хоёр хувааж үздэг. Урсгал шилжүүлэг нь:
 - Орлогын болон хөрөнгийн урсгал татвар
 - нийгмийн даатгалын шимтгэл
 - нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж (биет хэлбэрээс бусад)
 - бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ.
- Аливаа шилжүүлэг нь мөнгөн болон биет хэлбэрээр байж болно. Гэхдээ энэ дансанд биет хэлбэрийн нийгмийн халамжийн тэтгэмжийг хамруулахгүй.

3.2.3.1 Нөөцийн үзүүлэлт

Анхны орлогын үлдэгдэл/үндэсний орлого: Анхны орлого хуваарилалтын дансны ашиглалт талд бичигдсэн баланслуулах үзүүлэлт болох Анхны орлогын үлдэгдэл/Үндэсний орлогыг шууд авч тавина.

Орлогын болон хөрөнгийн урсгал татвар

Орлогын урсгал татвар: Энэ төрлийн татварт аж ахуйн нэгж, байгууллага, хүн амаас авч байгаа орлогын татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар хамрагдана.

Мэдээллийн эх үүсвэр: Улсын төсвийн орлогын мэдээнээс аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын мэдээллийг авч, Санхүүгийн болон санхүүгийн бус секторуудад тусгана. Секторуудаар хуваарилахдаа ҮТЕГ-ын албан ёсны мэдээллээр аж ахуйн нэгжийн төлсөн орлогын албан татварт дээрх секторуудын эзлэх хувийн жинг ашиглан тооцоог хийнэ. Улсын төсвийн орлогын мэдээнээс зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварыг авч, Санхүүгийн бус секторт тусгана. Улсын төсвийн орлогын мэдээнээс хүн амын орлогын албан татварыг авч, өрхийн аж ахуйн секторт тусгана.

Хөрөнгийн урсгал татвар: Уг татвар нь өмчийн ашиглалтаас олсон орлого болон өмч эзэмшигчийн хувьд төлдөг татвар. Аж ахуйн нэгж, байгууллага, хүн амын эд хөрөнгө, бууны татвар зэрэг байнга авдаг татвар, бусад төлбөр хураамжуудаас бүрдэнэ.

- Өмчийн татвар
 - Үл хөдлөх хөрөнгийн татвар

- Бууны албан татвар
- Бусад татвар (төлбөр, хураамжууд)
 - Улсын тэмдэгтийн хураамж
 - Ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр
 - Агнуурын нөөц ашигласны төлбөр
 - Байгалийн ургамал ашигласны төлбөр
 - Рашаан, ус ашигласны төлбөр
 - Бусад

Мэдээллийн эх үүсвэр: Улсын төсвийн орлогын мэдээнээс авч Төрийн байгууллагын секторт тусгана.

Нийгмийн даатгалын шимтгэл: Нийгмийн даатгалын шимтгэлийг Орлогын дахин хуваарилалтын дансанд өрхийн аж ахуйгаас бусад секторт өгч буй урсгал шилжүүлэг болгон тусгана.

Мэдээллийн эх үүсвэр: Анхны орлогын хуваарилалтын дансанд тусгагдсан нийгмийн даатгалын шимтгэлээс Улсын төсвийн орлогын мэдээнд тусгагдсан нийгмийн даатгалын орлогыг Төрийн байгууллагын секторт, үлдсэн хэсгийг санхүүгийн болон санхүүгийн бус секторуудын төлсөн шимтгэлийн эзлэх хувийн жинг ашиглан хуваарилна.

Нийгмийн халамжийн тэтгэмж: Нийгмийн халамжийн тэтгэмжид тогтмол олгогддог тэтгэвэр, тэтгэмжийг хамруулна. Эдгээр төрлийн тэтгэвэр, тэтгэмж нь тухайн үеийн хууль тогтоомжид тусгагдсан байх бөгөөд тогтмол буюу жил бүр эсвэл сар, улирал бүр олгогддог тэтгэмжүүд байна. Манай орны хувьд хуулийн дагуу дараахь төрлийн тэтгэвэр, тэтгэмжүүдийг улсын төсвөөс өрхөд шилжүүлдэг бөгөөд үүнийг орлогын дахин хуваарилалтын дансанд тусгана.

- Тэтгэвэр, тэтгэмжийн зардал
 - Өндөр настны тэтгэвэр
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр
 - Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
 - Цэргийн тэтгэвэр
 - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
 - Оршуулгын тэтгэмж
 - Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
 - ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж
 - Ажилгүйдлийн тэтгэмж
- Нийгмийн халамжийн зардал
 - Нийгмийн халамжийн тэтгэвэр
 - Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
 - Нярай хүүхэдтэй эхийн тэтгэмж
 - Хүүхэд асарсны тэтгэмж
 - Халамжийн бусад хөнгөлөлт, үйлчилгээний зардал
 - Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж
 - Өндөр настан, ахмад дайчдад олгох хөнгөлөлт
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт
 - Улсын баатрын болон одонгийн шагнал
 - Улсын баатар ахмад настан болон партизаны хөнгөлөлт
 - Олон хүүхэдтэй гэр бүлд олгох тэтгэлэг
 - Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж

Мэдээллийн эх үүсвэр: Улсын төсвийн зарлагын мэдээнээс үзүүлэлтийг авч Өрхийн аж ахуйн секторт тусгана.

Урсгал шилжүүлэг: Урсгал шилжүүлэг нь даатгалын цэвэр орлого, даатгалын нөхөлт, засгийн газар хоорондын урсгал шилжүүлэг, олон улсын хамтын ажиллагааны хүрээний урсгал шилжүүлэг, бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Даатгалын цэвэр орлого: Даатгалын байгууллагуудын эд хөрөнгийн даатгалын орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Мэдээллийн эх үүсвэр: Даатгалын салбарын бүтээгдэхүүний тооцооноос авч, Санхүүгийн секторт тусгана.

Даатгалын нөхөлт: Даатгалын байгууллагуудаас эд хөрөнгийн даатгалд олгосон нөхөн олговрын хэмжээг хэлнэ.

Мэдээллийн эх үүсвэр: Ашиглалт талд тусгасан даатгалын нөхөн олговрын нийт хэмжээг секторуудад тооцооны аргаар хуваарилна. Үүнд, бүтээгдэхүүний тооцооны завсрын хэрэглээнд тусгагдсан даатгалын зардлын дүнд эдийн засгийн секторуудын эзлэх хувийн жинг үндэслэн тооцно.

Засгийн газар хоорондын урсгал шилжүүлэг: Төрийн байгууллагын секторт хамаарах байгууллагуудын хооронд хийгдсэн мөнгөн шилжүүлгүүдийг оруулна. Энд хөрөнгийн хуримтлалтай холбоотой шилжүүлгүүд хамаарахгүй.

Мэдээллийн эх үүсвэр: Улсын нэгдсэн төсвийн зарлагын мэдээнээс засгийн газар хоорондын шилжүүлэг гэсэн үзүүлэлтийг авч, гадаад эдийн засгийн секторын ашиглалт талд тусгагдсан шилжүүлгийг нэмж, харин гадаад эдийн засгийн секторын нөөц талд тусгагдсан шилжүүлгийг хассан дүнг Төрийн байгууллагын секторт тусгана.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээний урсгал шилжүүлэг: Төрийн байгууллагын секторт хамаарах байгууллагуудын гадаадад шилжүүлсэн мөнгөн шилжүүлгүүдийг оруулна. Үүнд:

- Байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөхтэй холбогдсон Засгийн газар хоорондын болон байгууллага хоорондын мөнгөн ба материаллаг тусламжууд
- Олон улсын байгууллагын гишүүний татвар болон бусад төрлийн байнга төлдөг төлбөрүүд

Энд хөрөнгийн хуримтлалтай холбоотой шилжүүлгүүд үл хамаарна.

Мэдээллийн эх үүсвэр: Засгийн газарт гадаадаас шилжин ирсэн мөнгөн шилжүүлгийн хэмжээ буюу гадаад эдийн засгийн секторын ашиглалт талд тусгасан шилжүүлгийг Төрийн байгууллагын секторт тусгана.

